

まんがでわかる



Монгол хэл
モンゴル語


めっきの安全衛生

КОМИКООР МЭДЭХ

Бүрэлтийн аюулгүй байдал, эрүүл мэнд



Энэхүү дуу дүрст сургалтын материал нь бүрэлтийн үйл ажиллагааны электролизийн бүрэлтийн талбарт ажилладаг та бүхэнд зориулсан аюулгүй байдал болон эрүүл ахуйн үндсэн мэдлэг олгоход зориулан боловсруулсан материал болно.



Өнөөдөр бүрэлтийн ажлын аюулгүй байдал эрүүл ахуйн талаар суралцацгаая!




Зөвхөн гар ажиллагаа бус механик төхөөрөмж ч ашигладаг ажил тул аюулгүй байдалд анхаарахгүй бол болохгүй.

Тийм шүү!



Химийн уусмалыг ч бас ашиглах нь.


Юунд анхаарвал болох юм бол.



Тийм ажлын талбарт ч гэсэн үйлдвэрлэлийн осол үүсдэг юм шүү.

Хөөх ~!

Тэгэхээр, үйлдвэрлэлийн ослын гол шалтгааныг авч үзье.



Бүрэлтийн ажил дээр осолдож гэмтсэн хүмүүсийн байдал

1	Хавчуулагдах, орооцолдох	20 %
2	Ойчих	16 %
3	Хортой зүйлтэй хүрэлцэх	14 %
4	Унах, ойчих	10 %
5	Юм үсэрч ирэх, дээрээс юм унах	10 %


Нэмэлт: Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
"Үйлдвэрлэлийн осол гарсан байдал - Ажлын төрөл болон ослын хэлбэрээр" (2020 он)

* Бүрэлтийн ажил дахь үхэл болон ажлаа 4 хоногоос дээш хугацаагаар алдсан үйлдвэрлэлийн осол нь жилд 50 орчим удаа мэдээлэгддэг.



Хавчуулагдах, орооцолдох, ойчих, хортой зүйлтэй хүрэлцэх зэрэг нь олон байдаг байх нь ээ.





* Аюулгүй байдлыг хангах дүрэм журам нь зөвхөн хууль тогтоомжоор тогтохгүй, өнгөрөгч хугацаанд олон тохиолдсон алдаа болон ослоос авсан туршлагыг сургамж болгон боловсруулагддаг.



Бүрэх ажилд хэрэглэдэг зарим химийн бодисуудад (химийн уусмал) хүхрийн хүчил, давсны хүчил зэрэг хоруу чанар өндөртэй зүйл байдаг тул шууд хүрэхгүй байхад анхаарах хэрэгтэй.



Ялангуяа түлдэг бодис, хор бодистой харьцахдаа болгоомжтой байхгүй бол болохгүй.

Аюул осол хажууд байдаг байх нь.

Тиймээс дүрэм журмыг сайтар мөрдөж байх нь чухал.

Өөрийнхөө биеийг хамгаалахад хамгаалах хэрэгсэл өмсөх нь чухал.



Олон төрөл байдаг ч хийж байгаа зүйлдээ тулгуурлан зөвийг нь сонгох хэрэгтэй.

Ихэвчлэн ямар зүйлд анхаарах ёстой вэ?

4S гэдэг зүйлийг мэдэх үү?

4S гэдэг нь эмхлэх (Seiri), цэгцлэх (Seiton), цэвэрлэх (Seiso), цэмцгэр (Seiketsu) гэсэн үг. Энэ бол аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэс юм.



Хэрэгтэй хэрэггүйгээр нь ялгаж, хэрэггүй зүйлээ хая


Эмхлэх



Цэгцлэх



Цэвэрлэх



Цэмцгэр

Тэгэхээр дараа нь,


бодит ажлын талбайг,

харцгаая!

1

CASE 1

Химийн уусмалаас болгоомжилцгооё



Өө
урагдчих-
лаа!



Цоор-
чихлоо.

Гэхдээ жаахан л
юм чинь гайгүй байлгүй.



Ажил сайн
явж байна уу?



Одоо
химийн уусмал
нэмсэн нь
дээр шүү.

За,
ойлголоо.



Химийн бодис
хадгалах өрөө

薬剂保管室




Нөгөө химийн
уусмал
хаана байлаа?
... оллоо!



За аваад
явна аа.



Эхлээд
хамгаалалтын
шилээ сайтар
зүүнээ.



Өө
балараа!



Заа яаж байна даа?
Юу?
Нэг юман дээр гишгэчихлээ.



Өө, уучлаарай.
Хамгаалалтын шил эвдчихлээ.



Аа нүдэнд орчихлоо!



Хөөх өвдөж байна! яаая!



Түр хүлээж бай, яваад өөрийг аваад ирье.



Хамгаалалтын шил байхгүй байсан ч зүгээр байлгүй дээ. Хурдхан ажлаа эхлүүлье.



Хөөе зүгээр үү?



Нүдээ нээ, усаар угаая.




Хуруу жаахан салгалаад байх чинь.



За, нүд угаах тосгуурт угаахаар явлаа.



Бээлий чинь урагдсан байна, тайлдаа.



Химийн уусмалд арьс чинь түлэгдсэн байгаан биш үү.



Шууд эмнэлэг явна, машинд суу!



Санаа зовоосонд уучлаарай.



Хамгаалалтын хэрэгсэл биеийг чинь хамгаалахын төлөө байдаг юм шүү.

Богино хугацаанд ч гэсэн ажиллахдаа хамгаалалтын хэрэгсэл заавал зүүж бай.



Урагдсан, гэмтсэн хамгаалалтын хэрэгслийг ашиглахгүйгээр нэн даруй сольж байх.



За, сайн ойлголоо.

CASE 1 Дүгнэлт

1 Хамгаалалтын хэрэгслээ нандигнаж ашигла.



Өө, уучлаарай. Хамгаалалтын шил эвдчихлээ.



Ажилчдын дэргэдүүр өнгөрөхдөө хөл доорхоо ч анхаарч байгаарай.

2 Хамгаалах хэрэгсэл зүүж ажиллаарай!




Химийн уусмалыг юүлэхэд хуванцар савны амыг дээш харуулан зөөлөн юүлж, шингэний савнаас харьж урсахаас болгоомжил.

* Хэрэглэх химийн бодисын хор хөнөөлийг мэдэж байх нь чухал. Удирдагчаасаа асууцгаая.

TIPS Уусгагчийн саванд нүүрээ ойртуулахгүй!


БУРУУ




- Тос арилган цэвэрлэхэд ашигладаг уусгагчийн уурыг сороход амьсгал боогдох болон хурц хордлого үүсгэх аюултай.
- Өнгө болон үнэргүй уусгагч ч байдаг.
- Шөнийн цагаар болон баярын өдрүүдэд ганцаараа ажиллахгүй байгаарай. Ухаан алдсан үед олж мэдэхэд оройтдог.

CASE 2

Зөөх шугамд анхаарцгаая.



Бүгдийг өлгөж дууслаа.
Хоосон өлгүүрийг
буцааж тавья.



Цаасан хайрцаг
байгаа болохоор
явж болохгүй нь.



Юу ч гэж
энд тавьчихъя.
Дараа нь зөөхөд
болно доо.



Асуух
зүйл байна.




Нэг өлгүүр
дутаад байна.

Өөр хаа нэг
газар тавиагүй биз?



Зорчих хэсэгт
баахан цаасан
хайрцаг байсан болохоор
явж болдоггүй, түр
тэрний хажууд тавьсан.





Аа,
тэнд үү!
Ойлголоо.





Айн?



Өлгүүр унахаар байна!
Хурдан очиж
янзлахгүй бол!



Хөөе!
Юу хийгээд
байгаа юм?



Aaa!



Aaa!





Хөөе
зүгээр үү!?



Санаа
зовоочихлоо.



Өлгүүрийг
өлгөхдөө
буруу харж
байж байлаа.



Дассан байсан ч
хоёр гараараа
өлгөх шүү.



Үйлдвэрлэлийн шугамд
ямар нэг зүйл буруу
байгааг анзаарсан бол
ойр байгаа хүмүүст хэлж,
ослын зогсолт хийнэ.

Ажиллаж буй
машинд хүрэх нь
аюултай шүү.




Уучлаарай.
Би ч гэсэн
одооноос зөв
үед нь ярьж
байнаа.

CASE 2 Дүгнэлт

1 Үйлдвэрлэлийн шугамд
ямар нэг зүйл буруу байвал
хэлээрэй! Зогс!



Хөөе!
Юу хийгээд
байгаа юм?



Буруу зүйл ажиглагдвал ойрын хүмүүстээ хэлэхийн хажуугаар төхөөрөмжийг шууд зогсоож, төхөөрөмжид хүрэх үед бүрэн зогссон эсэхийг шалгаарай. Мөн, дахин ажиллуулах үед ялангуяа анхааралтай байх хэрэгтэй.

* Ажил хийж байгаа хүний нөхцөл байдлыг анзаарч ярилцъя.

2 Өлгүүр зэрэг хэрэгслийг
заасан газарт нь буцаан
байрлуулна.



Юу ч гэж
энд тавьчихъя.
Дараа нь зөөхөд
болно доо.

Зорчих хэсэгт эд зүйл тавьж орхихгүй байгаарай. Энэ нь бүдрэх зэргийн шалтгаан ч болж болзошгүй бөгөөд ойчих осол гаргах аюултай байдаг.

TIPS Зүлгэх ажилд анхаарах зүйлс



Орооцолдохоос
болгоомжил!

Хуруу, ажлын хувцасны ханцуй,
хормогчны зах гэх мэт.





Хамгаалах хэрэгсэл
заавал ашиглана!


Нүд, ам, хамар, гар зэргийг хамгаална.

* Өнгөлгөө хийхэд бээлий өмсөж болох эсэх талаар удирдагчийн зааврыг дагаж мөрдөөрэй.


CASE 3

Хөл доорхоо анхаарах






Чанга чимээ гарлаа,
ямар нэг юм болсон
болов уу?




Хөөе наад буцаах
хайрцгийг ачааны машин
хүртэл зөөгөөдөх!
Тавцант тэрэг
ашиглана шүү!

За,
ойлголоо.



Ингээд
бүгд дууслаа!

Байз?
Дахиад нэг хайрцаг
байхгүй байна уу?



Очиж
үзчихээд ир.


За,
үзчихээд ирье.



Өө тийм байна!
Нэг хайрцаг
байна.



Ахлахаа!
Байж байна!




Одоо
аваад очлоо!



Хөөе!
Аюултай
шүү дээ!




Зүгээр үү!?




Өлгүүрийг зөөхдөө хүчлэлгүй нэг нэгээр нь зөөнө. Тэгээд, ачааг зөөх үед хөл доорхоо анхаарахгүй бол аюултай шүү. Тавцант тэрэг ашиглаач.

ЗӨВ




БУРУУ




Дүрэмд зайлшгүй дагаж мөрдөхгүй бол болохгүй учир шалтгаан байдаг юм шүү.

Ойчиход хүргэдэг тул шал нойтон байвал арчаад,

шаардлагагүй зүйлсийг цэгцэлж байгаарай.



За, үргэлж анхаарч ажиллана.



CASE 3 Дүгнэлт

1 Нойтон шалнаас болгоомжил!



Шал гулгамтгай тул удаан алхаарай. Мөн, шал нойтон байвал нэн даруй арчина.

2 Шалны догол, поддоноос болгоомжил!



Гартаа юм барьсан үед хөл доорх зүйл харагдахгүй болох үе байдаг. Мөн, зорчих хэсэгт шаардлагагүй зүйлийг цэгцлээрэй.

TIPS Ийм газруудад ч анхаараарай!





Зогсож байгаа по өргөгчийн сэрээ



Шат болон догол



Хоолой, утас, олс



Хамгаалалтын хэрэгсэл


Зориулалтад нийцсэн хамгаалах хэрэгсэл ашиглацгаая!



Бээлий

Химийн уусмал болон хурц үзүүртэй зүйлээс гарыг хамгаалах зүйл

Химийн бүтээгдэхүүнд тэсвэртэй материалтай бөгөөд, ажилд хэрэглэгдэх химийн бодистой нийцэх зүйл ашиглах



Хамгаалалтын шил

Химийн уусмал болон үсэрч ирэх зүйлээс нүдийг хамгаалах зүйл

Ажилд тохирсон зүйлийг ашиглах.



Хормогч

Химийн уусмал зэргээс биеийг хамгаалах зүйл


Аль болох өндөр байрлалаас зүүнэ.




Хамгаалалтын комбинезон

Химийн уусмал зэргээс биеийг хамгаалах зүйл

Өөрт тохирсон хэмжээтэйг өмсөнө.




Амьсгалын хамгаалалтын хэрэгсэл



Хийн маск

Хорт хий, уур зэргийг амьсгалахаас сэргийлдэг зүйл.

- Хортой бодисын төрөл, концентрацид тохирохыг нь хэрэглэх.
- Өмсөхөд тохиромжтой байдлыг шалгах (Эвтэйхэн байдлыг шалгах)
- Шүүлтүүр болон хураах савыг солих
- Нэг удаагийн төрөлтэй бол ашиглах хугацааг баримтлах.



Химийн бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар амьсгалахад биед сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Малгай

Химийн уусмал болон үсэрч ирэх зүйлээс толгойн хэсгийг хамгаалах зүйл

Өөрт тохирсон хэмжээтэй малгай өмсөх. Урт үсийг боож, дотор хийж өмсөх.



Дуулга

Толгойг цохилтоос хамгаалдаг зүйл

Эрүүний түгжээг тааруулж, хөдөлгөхгүйн тулд сайтар чангал. Нэг удаа ч гэсэн цохилт авсан малгайг сольж байх.



Түрийтэй гутал

Химийн уусмал зэргээс хөлийг хамгаалах зүйл

Өөрт тохирсон хэмжээтэй гутал өмсөх. Ажилдаа тохирохыг нь ашиглах.



Хамгаалалтын гутал

Хүнд зүйл унахад хөлийг хамгаалах зүйл

Өөрт тохирсон хэмжээтэй гутал өмсөх. Ажилдаа тохирохыг нь ашиглах.



Хамгаалах хэрэгслийг ажилд тохирсон зүйл байхаар сонгож, зөв хэрэглэхгүй бол утгагүй болно!

Авах арга хэмжээний санаа 1

Зөв зүүж, зөв хэрэглэ!

Хөдөлгөөн болон завсар байхгүй байхаар!



Авах арга хэмжээний санаа 2

Биеийн хэмжээнд тохирсон хамгаалах хэрэгсэл хэрэглэ!

Хэмжээ таарахгүй бол нэн даруй солиулах.



Авах арга хэмжээний санаа 3


Бохирдсон, эвдэрсэн чигээр нь байлгахгүй!



Бохирдлыг цэвэрлэх.



Эвдэрч, нүх гарсан бол солих.



Цэвэр газар хадгалах.

КОМИКООР МЭДЭХ

Бүрэлтийн аюулгүй байдал, эрүүл мэнд

2022 оны 3-р сарын хэвлэл

Хэвлүүлсэн: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам

Төлөвлөн хэрэгжүүлсэн: Mizuho Research & Technologies, Ltd.

Хамтран ажилласан: Бүрэлтийн аюулгүй байдал эрүүл ахуйн боловсрол
сургалтын материал боловсруулах ажлын хэсэг

Хэвлэсэн: Sideranch Inc.



Энэ материалтай холбоотой холбоо барих
Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яамны
Хөдөлмөрийн стандартын товчооны
Аюулгүй ажиллагааны хэлтэс,
Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар